



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар

A/181

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Гранд лүүк” ХХК-ний Нийтийн эзэмшлийн талбайд гоёлын модны суулгац, тарьж нийлүүлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Туулайтулга	- Жаргалант сумын Засаг даргын орлогч
Гишүүд: Ц.Пүрэвсүрэн	- Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Ц.Цолмонбаатар	- Стандарт хэмжилзүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
Ц.Даваасамбуу	- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
С.Батдорж	- Аймгийн архивын тасгийн дарга
Н.Алдар	- “Гранд лүүк” ХХК-ийн захирал
Нарийн бичгийн дарга: Б.Наранбаатар	- “Шинэ ховд баруун бүсийн хөгжлийн корпораци” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын мэргэжилтэн

2. “Гранд лүүк” ХХК-ий хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Туулайтулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Т.ЖАРГАЛСАЙХАН

8400 61 0311

D/Zah-A/181-Bo